

МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ТАЖИКИСТАН УЛС ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ЗАРЧМЫН ТУХАЙ ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаярын урилгаар Бүгд Найрамдах Тажикистан Улсын Ерөнхийлөгч Эмомали Рахмон 2009 оны 3 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

Монгол, Тажикистаны дээд хэмжээний анхны уулзалтын үеэр талууд хоёр талын харилцааны болон харилцан сонирхсон олон улсын асуудлуудаар санал солилцов.

Талууд дараах мэдэгдэл хийж байна:

1. Хоёр орны харилцааг бүх салбарт тогтоон цаашид хөгжүүлэх нь хоёр ард түмний язгуур эрх ашиг, хүсэл эрмэлзэлд нийцэж, Ази болон дэлхийн энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд тус дэм болно гэж Талууд үзэж байна.

2. Монгол Улс, Бүгд Найрамдах Тажикистан Улсууд нь бие биеийнхээ тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмуудад тулгуурлан харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх болно. Талууд бүх улс орон, том жижиг, хүчтэй хүчгүй, баян ядуугаас үл хамааран дэлхийн хамтын нийгэмлэгт адил тэгш эрх эдлэх ёстой гэж үзэж байна. Улс бүр өөрийн өвөрмөц онцлогийг харгалзан, нийгмийн байгуулал, эдийн засгийн хэлбэр, хөгжлийн замаа өөрөө сонгох бүрэн эрхтэй. Энэ талаарх ялгаа нь улс хоорондын хэвийн харилцааг хөгжүүлэхэд саад болох учиргүй.

3. Монгол Улс, Бүгд Найрамдах Тажикистан Улсын удирдагчид эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь хоёр талын харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж байна. Талууд эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмуудад тулгуурлан эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлэх бөгөөд хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүдийг дэмжих болно.

4. Талууд хоёр талын хамтын ажиллагааг шинжлэх ухаан-техник, боловсрол, соёл, мэдээлэл, эрүүлийг хамгаалах, аялал жуучлал, биеийн тамир спортын зэрэг салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийг дэмжих болно.

5. Талууд төвийн болон орон нутгийн төр засаг, олон нийтийн байгууллага хоорондын харилцааг өргөжүүлэхийн төлөө шаардлагатай арга хэмжээг авах болно.

6. Талууд хоёр талын хамтын ажиллагаа болон харилцан сонирхсон олон улсын бусад асуудлуудаар янз бүрийн түвшинд зөвлөлдөх уулзалт байнга зохион байгуулна.

7. Талууд НҮБ-ын дүрмийн зорилго, зарчмыг баримтлаж байгаагаа нотолж, дэлхийн энх тайван, олон улсын аюулгүй байдал, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн хэм хэмжээг үр ашигтайгаар хэрэгжүүлэх үйлсэд НҮБ-ын нэр төр, гүйцэтгэх үүрэг ролийг бэхжүүлэхийн төлөө байна.

8. Хоёр улс дэлхийн энх тайван, хөгжил, зэвсэг хураах, зэвсэглэлээр хөөцөлдөхөөс урьдчилан сэргийлэх, дэлхий нийтийн уур амьсгалын өөрчлөлт зэрэг орчин үеийн гол асуудлууд болон бусад асуудлаар ижил төстэй байр суурь баримталдаг. Талууд Ази, Номхон далайн бүс нутаг болон дэлхийн энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдлыг ханган бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно.

9. Талууд бүс нутгийн улс орнуудын сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааны хөгжилд болон Монгол Улс, ШХАБ-ын хоорондын хамтын ажиллагаанд ШХАБ чухал үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглээд эрчим хүч, дэд бүтэц, харилцаа холбоо, тээврийн зэрэг салбарт хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Бүгд Найрамдах Тажикистан Улс энэ чиглэлээр хийж буй Монгол Улсын хүчин чармайлыг сайшаан дэмжиж байна.

10. Монголын тал Төв Азийн таван улсын төлөөлөгчид 2006 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр гарын үсэг зурсан Төв Азийн цөмийн зэвсэггүй бүсийн тухай Гэрээ хүчин төгөлдөр болсныг сайшааж, энэхүү бүсийг байгуулсан нь цөмийн зэвсгийг хураах олон улсын хүчин чармайлыг бэхжүүлэх, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийг сахиулах үйл хэрэгт эерэг алхам болсон бөгөөд дэлхийн болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангахад бодит хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.

11. Өнгөрсөн 2008 оны 10 дугаар сард Алматын Үйл ажиллагааны хөтөлбөрийн дунд хугацааны биелэлтийн явцыг авч хэлэлцсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн өндөр хэмжээний тусгай хуралдаанаас далайд гарцгүй хөгжиж буй орнуудад зориулсан олон улсын судалгааны төв ("Think Tank")-ийг Улаанбаатар хотноо байгуулах НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрийг санал нэгтэй дэмжсэнийг хоёр тал дахин нотолж байна.

12. Талууд зохион байгуулалттай гэмт хэрэг, олон улсын терроризм, мансууруулах болон сэтгэгцэд нөлөөлөх бодисын хууль

бус худалдаа, хууль бус зэвсгийн наймаа болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллана.

13. Монгол Улс, Бүгд Найрамдах Тажикистан Улсын удирдагчид Монгол, Тажикистаны дээд хэмжээний анхны уулзалтын дүнд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлээд хоёр орны харилцаа зарчмын шинэ шатанд гарсныг өндрөөр үнэлэв.

14. Талууд хоёр орны харилцааг цаашид хөгжүүлэх өргөн төлөв байгаад итгэлтэй байгаагаа илэрхийлж, түүнийг бүрэн хэрэгжүүлэхийн төлөө бүх талын хүчин чармайлт гаргах болов.

2009 оны 3 дугаар сарын 27-ны өдөр
Улаанбаатар хот